

## ТАНИЛЦУУЛГА

*Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар*

Зохиогчийн эрхийн салбарт гарч буй өөрчлөлт шинэчлэлт нь технологийн хөгжил дэвшилтэй шууд хамааралтай бөгөөд технологи хөгжихийн хэрээр бүтээлийн төрөл улам олширч, шинэ нэр томъёо, ойлголтууд бий болж, нөгөө талаас зохиогчийн эрхийг зөрчих, бүтээлийг илүү хялбар аргаар хувилан олшруулж, ажиллагааг улам хялбаршуулж байдаг нь энэ хуулийн зохицуулалт цаг үеэ дагаад улам нарийн, боловсронгуй болж байх шаардлагатай болж байдаг.

Монгол Улсын Их Хурал 1993 онд Зохиогчийн эрхийн тухай хуулийн баталсан байдаг бөгөөд зохиогчийн эрхийн олон улсын гэрээ, конвенц болон нийгэм, эдийн засгийн харилцааны шинэчлэлтэй уялдуулан 2006 онд шинэчлэн найруулгыг баталсан байна.

Гэвч хуулийг хэрэгжүүлэх явцад оюуны бүтээлийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй ашиглах, хуулбарлах, хууль бусаар орлого олох явдал эрс өсөн нэмэгдэж, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зохицуулалтыг боловсронгуй болгох, цахим болон харилцаа холбооны бусад сүлжээ, өргөн нэвтрүүлэг, олон суваг дамжуулагч, дуу хөгжим, дуу авиа бүхий дүрст бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, зохиогч, эрх эзэмшигчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг нарийвчлан тодорхойлох шаардлага үүсээд байна.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг өөрийн орны онцлог, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалтын олон улсын гэрээ, конвенц, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас гаргасан заавар, зөвлөмж болон бусад улс орны нийтлэг зохицуулалт, чиг хандлагатай нийцүүлэн доор дурдсан шинэлэг зохицуулалт тусган боловсрууллаа. Үүнд:

1. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод компьютерийн програм, мэдээллийн сан, бүтээл, хамаарах эрх эзэмшигч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон суваг дамжуулагч, дуу авиа бүхий дүрст бүтээлийн продюсер, эшлэл, дамжуулах, дахин дамжуулах, нийтэд тоглох, нийтэд дэлгэж үзүүлэх, нийтийн хүртээл болгох, түрээслэх, зээлдүүлэх гэх мэт нэр томъёоны тодорхойлолтыг нэмж, зарим нэр томъёог өөрчлөн найруулсан.

2. Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 70 жилийн хугацаанд, хамаарах эрхийн объектыг хамаарах эрхийн объектийг туурвисан, эсхүл гүйцэтгэсэнээс эхлэн 50 жилийн хугацаанд хамгаалахаар тусгасан.

3. Зарим бүтээлийн зохиогчийн эрхийн онцлогийг дэлгэрэнгүй тусгасан. Үүнд үүсмэл бүтээл, албан үүргийн дагуу туурвисан бүтээл, кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээл, компьютерийн програм, мэдээллийн сан, дүрслэх урлагийн бүтээл, архитектурын бүтээлийн зохиогчийн эрхийг нарийвчлан тодорхойлсон.

4.Зохиогчийн эрхэд хамаарах эрх болох уран бүтээлч, фонограм бүтээгч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэгийн продюсерын эдлэх эрхийг дэлгэрэнгүй тодорхойлсон.

5.Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг ашиглах эрх (лиценз) олгох замаар бүтээлийг бусдад ашиглуулах үндсэн арга хэлбэрийг тодорхойлсон. Түүнчлэн бүтээл ашиглах эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээний нөхцөлийг нарийвчлан тусгасан.

6.Зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг буюу бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдлуудыг нарийвчлан тодорхойлсон.

7.Дүрслэх урлагийн бүтээлтэй холбоотой зохицуулалт тодорхой бус учраас эрх эзэмшигч, зохиогчид багагүй хохирол учирч байгааг зохицуулж, дүрслэх урлагийн бүтээлийг дахин борлуулалтын үнийн дүнгээс зохиогчид тодорхой хувийг төлдөг байх зохицуулалтыг нэмж тусгасан.

8.Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэх, ийм бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан үйлчилгээ үзүүлэх байгууллагаас хилээр нэвтрүүлэх, хуулбарлах, нийтэд түгээхэд зохиогчийн эрхийг хязгаарлах, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгасан.

9.Цахим орчноос гадна харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах нөхцөлийг нэмж тусгасан.

10.Зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зөвлөх, хянах, гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Зохиогчийн болон хамаарах эрхийн зөвлөлийг байгуулах эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон.

11.Зохиогч, эрх эзэмшигчдийн эрхээ төлөөлүүлэн хэрэгжүүлэх, хамгаалуулах үндсэн хэлбэр болох хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон. Тодруулбал хамтын удирдлагын байгууллагад тавих шаардлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаандаа ил тод, шуурхай байдал болон үнэн зөв, бодит мэдээллийг хангаж ажиллах эрх зүйн орчныг бий болгож, уг харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхлын тэнцвэр хангагдах боломжийг бүрдүүлсэн.

12.Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч хүсвэл бүтээл болон бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх гэрээ, хэлцлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх, бүртгэл хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан.

13.1993 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө туурвисан бүтээлийн зохиогчийн эрх болон хамаарах эрхийг хэрхэн хэрэгжүүлэх, хамгаалах талаар одоогийн дагаж мөрдөж буй хуульд тодорхойгүй байдаг тул 1993 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө туурвисан бүтээлийн зохиогчийн эрх болон хамаарах эрхийг хамгаалах талаар шилжилтийн зохицуулалтыг нэмж тусгасан.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**